



ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН 2024

"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК



(976) 7021-0167



baganuur@bnedo.mn



АГУУЛГА

НЭГ. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
ХОЁР. БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ	5
2.1. Хүний нөөцийн бодлого, шилжилт хөдөлгөөн	6
2.2. Ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр:.....	9
2.3. Хүний нөөцийн судалгаа	10
2.4. Хууль, эрх зүйн чиглэлээр	12
2.5. Сургалтын чиглэлээр	13
ГУРАВ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР	15
3.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын талаар	15
3.2. Мэдлэгийн сургалт, шалгалтын талаар	20
ДӨРӨВ. ЦАХИЛГААН ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР	21
4.1. Техникийн нөхцөл олголтын талаар:	21
4.2. Ашиглалтын ажлын талаар:	23
4.3. Засварын ажлын талаар	26
4.4. Хэрэглэгчийг стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр хангах ажлын талаар	36
4.5. Урсгал засварын ажлын талаар	37
4.6. Инновацийн чиглэлээр хийсэн ажлын талаар	38
4.7. Горимын талаар	38
4.8. Төсвийн ажлын чиглэлээр	41
4.9. Стандарт, судалгааны ажлын чиглэлээр.....	42
4.10. Шуурхай ажиллагааны чиглэлээр	43
ТАВ. ЦАХИЛГААНААР ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР	46
5.1. Худалдан авсан цахилгаан эрчим хүч	46
5.2. Борлуулсан цахилгаан эрчим хүч	47
5.3. Цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдал	48
5.4. Цахилгаан эрчим хүчний авлага	49
5.5. Хэрэглээний бүтэц.....	50
5.6. Хэрэглэгчийн тоо	51
5.7. Хэрэглэгчдээс ирсэн санал хүсэлтийг шийдвэрлэсэн байдал:	51
5.8. Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр	52
5.9. Дуудлагын төвийн үйл ажиллагаа.....	54
5.10. Тоолуур, хэмжүүрийн чиглэлээр	56
ЗУРГАА.ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР	58

6.1. Компанийн 2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө, гүйцэтгэл.....	58
6.2. Худалдан авалтын хэмнэлт.....	58
6.3. Сангийн яаманд гаргасан гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдал.....	59
6.4. Дотоодын үйлдвэрээс худалдан авсан бараа, бүтээгдэхүүн	59
ДОЛОО. 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ.....	61



АЛСЫН ХАРАА

Бид дэлхийн жишигт хүрнэ.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол орны зүүн өмнөд бүсийн хөгжлийн хөтлөгч нь байж, хэрэглэгчдэд чанартай цахилгаан эрчим хүчийг тасралтгүй ханган түгээгч, хэрэглэгч, хамт олноо дээдэлсэн тэргүүлэх компани байх болно.



ҮНЭТ ЗҮЙЛС

Хэрэглэгчдээ дээдлэх
Хуулийн хүрээнд ажиллах чадвар
Ил тод шударга байдал
Чанар хариуцлага
Сахилга бат
Мэргэжлийн ур чадвартай, бүтээлч байх
Хуримтлуулсан ажлын туршлага

НЭГ. КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Тус компани нь анх Бүгд найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын зөвлөлийн 1984 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 328 дугаар тогтоолоор “БАГАНУУР ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР” нэртэйгээр байгуулагдсан.

Монгол Улсын Их Хурлаас Эрчим хүчний тухай хуулийг 2001 онд шинэчлэн баталж, эрчим хүчний байгууллагуудыг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрлийн эрх бүхий бие даасан компаниуд болгон шинэчлэн байгуулснаар Засгийн газрын 2001 оны 07 дугаар сарын 164 дүгээр тогтоолоор “БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК болж бүтэц, зохион байгуулалтын хувьд өөрчлөгдсөн.

Тус компани нь ашиглалт үйлчилгээний заагаар хойд тал нь Хэнтий аймгийн Дадал сумаас урд тал нь Дорноговь аймгийн Ханги хилийн боомт хүртэл, зүүн тал нь Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумаас, баруун тал нь Дундговь аймгийн Дэлгэрхангай сум хүртэл, нийт 276.6 м² газар нутаг дахь нийслэлийн Багануур дүүрэг, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймгуудын төв, 7 аймгийн 58 сум, суурин газрын нутаг дэвсгэрт байрлах 55950 хэрэглэгчдэд дараах дараах тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

1. Цахилгаан түгээх
2. Цахилгаанаар зохицуулалттай хангах;
3. Цахилгаан импортлох (БНХАУ)-аас
4. Монгол улсад ашиглахыг зөвшөөрсөн загварын цахилгааны тоолуур, гүйдлийн трансформатор суурилуулах, засварлах
5. 0.4-110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ

Тус компани нь дээрх таван тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хүрээнд түгээх, хангах үйл ажиллагааны чиглэлээр жилд дунджаар 551.3 сая.кВт.цаг цахилгаан эрчим хүчийг худалдан авч, худалдан авсан цахилгаан эрчим хүчний 6.96% буюу 37.9 сая.кВт.цаг цахилгаан эрчим хүчийг түгээлтэд алдаж, 516.2 сая.кВт.цаг цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчдэд түгээн борлуулж байна.


0,4–110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээний тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хүрээнд 110 кВ-ын 2, 35 кВ-ын 46, 22кВ-ын 2, 20.2/0.22 болон 6/10/15 кВ-ын 517, нийт 567 дэд станц, 4482.8 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 170.3 км кабель шугамын ашиглалт, засварын ажлыг хариуцан ажиллаж байна.

Цахилгаан, соронзон хэмжлийн хэмжих хэрэгслийг суурилуулах, засварлах, худалдах тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хүрээнд компаний нийт ахуйн болон үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага, дэд станцуудын 1 ба 3 фазын цахилгаан эрчим хүчний тоолуурууд, гүйдлийн трансформаторууд, хэмжүүр хэмжих хэрэгслүүд, хэмжүүрийн багажуудын шалгалт, тохируулгыг хийж гүйцэтгэн эдгээрийн баталгаажуулалтыг Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн газар болон тус газрын аймаг орон нутаг дахь салбаруудтай хамтран гүйцэтгэж байна.

Цахилгаан импортлох тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хүрээнд Дорноговь аймгийн Ханги хилийн боомтоор БНХАУ-аас 2.8 сая.кВт*ц цахилгаан эрчим хүчийг импортоор худалдан авч байна.

ХОЁР. БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь Бүтэц, зохион байгуулалтын хувьд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 16 дугаар тогтоолоор баталсны дагуу орон тооны дээд хязгаар 555, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан зохион байгуулалтын бүтцийн дагуу 5 салбар, 8 хэлтэс, 4 албаны нийт 531 ажилтантайгаар компанийн чиг үүргийг хэрэгжүүлэв.



Компанийн үйл ажиллагаа, онцлогт нийцсэн стратегийн зорилгыг Монгол Улсын төрийн бодлого, хууль тогтоомж, эрчим хүчний салбарын өнөөгийн болон ирээдүйн чиг хандлагатай уялдуулж, судалгаа шинжилгээнд үндэслэн тодорхойлж, олон улсын жишигт нийцсэн стратегийн баримт бичгийг боловсруулах ажлыг эхлүүлж, шаардагдах төсвийг 2024 оны бизнес төлөвлөгөөнд батлуулснаар 2024-2030 оны стратегийн баримт бичгийг боловсруулах ажлын тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, “Өгөгдөл, шинжилгээ, загварчлалын төв” НҮТББ гүйцэтгэгчээр шалгаран компанийн мандат, алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс болон компанийн хөгжлийн бодлогын зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх үндсэн чиглэлүүд бүхий стратегийн баримт бичгийг боловсруулсан.

Компанийн хэвийн тогтвортой үйл ажиллагааг хангаж ажиллах хүрээнд гүйцэтгэх захирал болон харьяа салбарын даргаас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 635 тушаал, хүний нөөцийн чиглэлээр 1479 тушаалыг хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, биелэлтийг хангаж ажилласан байна.

2024 онд компани болон харьяа салбарт 4196 албан бичиг, 2841 өргөдөл ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн ба 3615 албан бичгийг стандартын дагуу албажуулан зохион байгууллагад хүргүүлэв.

Компанийн хэмжээнд дотооддоо мөрдөгдөх 77 баримт бичиг, дүрэм, журам, заавар мөрдөгдөж байгаа бөгөөд компанийн менежментийг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийг мөрдүүлэх зорилгоор 2024 онд 10 журам, зааврыг шинэчлэн боловсруулж баталсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар компанийн үйл ажиллагаатай холбоотой 29 тогтоол, 8 хурлын шийдвэрийг мөрдөж ажилласан ба компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүргүүлсэн.

2.1. Хүний нөөцийн бодлого, шилжилт хөдөлгөөн

Компанийн хэмжээнд хүний нөөцийн бодлогыг зөв оновчтой тодорхойлох, мэргэжлийн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах, сургаж хөгжүүлэх, тогтоон барих, ажилтны манлайллыг бий болгох, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажилтныг урамшуулан шагнах замаар гүйцэтгэлд суурилсан бүтээлч, чадварлаг, тогтвор суурьшилтай хүний нөөцийг бий болгож байгууллагын тогтвортой хөгжлийг хангах, өрсөлдөх чадвар бүхий мэргэжлийн чадварлаг хамт олныг бүрдүүлж, тэднийг үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогыг хэрэгжүүлж 2018 онд батлагдсан “Хүний нөөцийн бодлогын бичиг баримт”-ыг хамаарах чиглэлийн үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллалаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 16 дугаар тогтоолоор баталсны дагуу орон тооны дээд хязгаар 555, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан зохион байгуулалтын бүтцийн дагуу 5 салбар, 8 хэлтэс, 4 албатай, шаталсан удирдлагын тогтолцоо, бүтэц зохион байгуулалтын функциональ хэлбэрийг сонгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн бүтэц, зохион байгуулалтын хувьд Дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2”-ын хүрээнд тус төслийн үйл ажиллагааг компанийн хэмжээнд хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий Төслийн нэгжийг 2017 онд байгуулсныг компанийн хэмжээнд хийгдэх ажлууд дууссантай холбогдуулан “Эрчим хүчний төсөл-2”-ын нэгжийг зохион байгуулалтын бүтцээс хасаж, цахилгаан эрчим хүчний хангамжийн чанар, тасалдал, тасралт зэрэг доголдол, дуудлага үйлчилгээ, төлбөрийн болон бусад асуудлуудын талаарх хэрэглэгчдээс ирэх санал, хүсэлт, дуудлагуудыг компанийн харьяа 5 салбарт тус тусдаа байгууллагын уламжлалт телефон аппарат ашиглан, гараар бүртгэлжүүлэн тэмдэглэл хийж гүйцэтгэдэг байсныг үүрэн телефоны оператор, интернет сүлжээ, компьютер техник, программ хангамжийн орчин үеийн системийг ашиглан шинэ түвшинд гаргаж, дуудлагыг бүрэн хүлээн авч, шийдвэрлэх бусад программ хангамж, системүүдтэй хослон, дэмжиж ажиллах зорилгоор компанийн дуудлагын үйлчилгээнд Call Center буюу “Дуудлагын төв”-ийг байгуулах өөрчлөлтүүдийг хийсэн.

Компани нь “Эрчим хүчний төсөл-2”-ийн хүрээнд цахилгаан эрчим хүчийг түгээн борлуулах үйл явцыг хялбаршуулж, нийт хэрэглэгчдийнхээ 65%-ийг ухаалаг сүлжээнд хамруулж чадсан ба компанийн эзэмшлийн дэд станцуудыг СКАДА системд холбох, тасралтын мэдээлэл хүргэх төхөөрөмж суурилуулах, дуудлагын нэгдсэн “Call Center” үйлчилгээ нэвтрүүлэх, санхүү, хүний нөөц, борлуулалт, хангах үйл ажиллагааг нэгдсэн байдлаар уялдуулсан удирдлагын мэдээллийн цахим системийг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх зэргээр цахим технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг зорин ажилласнаар 2024 онд 12 орон тоог бусад шаардлагатай нэгжид шилжүүлэх боломж бүрдсэн.



Компанийн хэмжээнд 2024 онд шинээр 146 ажилтан томилогдож, 131 ажилтан ажлаас чөлөөлөгдсөн, компани болон салбар дотроо ажлын байр нь өөрчлөгдсөн 74, нийт 351 шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна.

**Гүйцэтгэх захирал болон харьяа салбарын даргын тушаал
(2021-2024 он)**

Д/д	Нийт орон тоо	558		555		555		555	
	Он	2021 он		2022 он		2023 он		2024 он	
	Тоон үзүүлэлт	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
2	Ажилд шинээр томилогдсон	89	15.9	181	32.7	115	20.7	111	20.3
3	Ажилд түр томилогдсон ажилтан	58	10.4	33	6.0	20	3.6	35	63.0
4	Ажлын байр, албан тушаал өөрчлөгдсөн	98	17.6	192	34.7	101	18.2	73	13.1
5	Ажлаас чөлөөлөгдсөн ажилтан	80	14.3	175	31.6	116	20.9	131	23.6
6	Сахилгын шийтгэл ногдуулсан	78	14.0	62	34.3	115	20.7	87	15.6
7	Ажлын 5 хоногоос дээш чөлөө олгосон	119	21.3	158	28.6	217	39.1	161	29.0
8	Ур чадвар, хослон, орлон ажилласны нэмэгдэл олгосон	37	6.6	75	39.1	93	16.8	75	13.5
9	Албан тушаал дэвшсэн	17	3.0	31	17.7	17	3.1	12	2.1
10	Албан тушаал буурсан	5	0.9	18	29.0	7	1.3	2	0.3
11	Бусад салбараас шилжиж ирсэн	8	1.4	13	8.2	3	0.5	10	10.0
12	Бусад салбар луу шилжсэн	6	1.1	16	21.3	4	0.7	13	2.0
13	Дагалдан, туршилтын хугацаанаас жинхэлсэн	127	22.8	129	416.1	150	27.0	134	24.0
14	Хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа орсон	4	0.7	6	33.3	11	2.0	55	9.0
Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнууд-нийт		80	14.3	197	152.7	141	25.4	131	23.0
15	Удирдах албан тушаалтан	3	0.5	4	66.7	2	0.4	7	1.0
	Инженер техникийн ажилтан	18	3.2	46	418.2	46	8.3	38	6.0
	Албан хаагч	3	0.5	14	175.0	9	1.6	16	2.0
	Бага тушаалын ажилтан	56	10.0	10	5.1	122	22.0	70	12.0
16	Ажилд томилогдсон ажилтнууд-нийт	89	15.9	140	3500.0	115	20.7	146	26.0
	Удирдах албан тушаалтан	6	1.1	4	8.7	3	0.5	2	1.1
	Инженер техникийн ажилтан	24	4.3	50	357.1	21	3.8	48	5.0
	Албан хаагч	5	0.9	10	100.0	9	1.6	21	3.0
	Бага тушаалын ажилтан	54	9.7	125	89.3	83	15.0	75	13.0

**Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн
(2021-2024 он)**

	2021 он		2022 он		2023 он		2024 он	
	Ажлаас чөлөөлөг дсөн	Шинээр томилогд сон	Ажлаас чөлөөлөг дсөн	Шинээр томилогд сон	Ажлаас чөлөөлөг дсөн	Шинээр томилогд сон	Ажлаас чөлөөлөг дсөн	Шинээр томилогд сон
Удирдах албан тушаалтан	3.8	6.7	5.4	5.8	1.1	2.6	5.0	1.4
Инженер техникийн ажилтан	22.5	27.0	62.2	72.5	25.7	18.1	29.0	32.9
Албан хаагч	3.8	5.6	18.9	14.5	5.0	7.8	12.2	14.4
Бага тушаалын ажилтан	70.0	60.7	13.5	7.2	68.2	71.6	53.4	51.4
Нийт	100	100	100	100	100	100	100	100

**Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн, салбараар
(2021-2024 он)**

Салбар	2021 он	2022 он	2023 он	2024 он
Төв компани	9.2	22.4	18.1	20.8
Багануур ЦТСС	11.7	32.1	25.6	38.0
Говьсүмбэр ЦТСС	15.2	39.7	37.2	18.5
Дорноговь ЦТСС	28.1	70.5	30.8	33.0
Дундговь ЦТСС	10.4	15.4	16.9	14.3
Хэнтий ЦТСС	11.2	25.9	11.2	19.8

**Шилжилт хөдөлгөөнийг ажил мэргэжлийн бүлэг индексээр
харьцуулсан байдал (2021-2024 он)**

Д/д	Он	2021 он	2022 он	2023 он	2024 он
	Ажилтны тоо	551	548	529	531
1	Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнууд-нийт	80	74	179	133
2	Удирдах албан тушаалтан	3	4	2	5
3	Шилжилт хөдөлгөөний хувь	4%	5%	1%	4%
4	Инженер техникийн ажилтан	18	46	46	39
5	Шилжилт хөдөлгөөний хувь	23%	62%	26%	29%
6	Албан хаагч	3	14	9	15
7	Шилжилт хөдөлгөөний хувь	4%	19%	5%	11%
8	Бага тушаалын ажилтан	56	10	122	74
9	Шилжилт хөдөлгөөний хувь	70%	14%	68%	56%
Д/д	Ажилд томилогдсон ажилтнууд-нийт	89	69	116	145
1	Удирдах албан тушаалтан	6	4	3	2
2	Шилжилт хөдөлгөөний хувь	7%	6%	3%	1%
3	Инженер техникийн ажилтан	24	50	21	48
4	Шилжилт хөдөлгөөний хувь	27%	72%	18%	33%



5	Албан хаагч	5	10	9	20
6	Шилжилт хөдөлгөөний хувь	6%	14%	8%	14%
7	Бага тушаалын ажилтан	54	5	83	75
8	Шилжилт хөдөлгөөний хувь	61%	7%	72%	52%

Хүний нөөцийн төлөвлөлт, хэрэгцээнд үндэслэн тус компанийн хэлтэс, алба, нэгжийн удирдлагууд нь шаардлагатай байгаа сул болон шинээр бий болсон ажлын байрны захиалгыг “Хүний нөөцийн захиалга өгөх хуудас”-аар Захиргаа хүний нөөцийн хэлтэст ирүүлснээр Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 дугаартай “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК -ийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах журам”-ын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажилласан ба шилжилт хөдөлгөөн өмнөх оноос 2.8 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

2.2. Ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр:

Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан “Хамтын гэрээ”, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Төрийн хэмнэлтийн хуульд нийцүүлэн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж, гүйцэтгэж байгаа ажил үүрэг, ур чадварт нийцсэн цалин хөлсийг олгох зорилгоор ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 21,132.6 сая төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 17.9 хувиар нэмэгдсэн байна.

Үндсэн ба тарифт цалинг нэмэгдүүлснээр нэг ажилтны дундаж цалин ЖҮДНХ-тэй 3062.9 мянган төгрөгт хүрч, өмнөх оноос 30.0 хувиар нэмэгдүүлсэн.

ЭМ-ийн сайдын 2014 оны 340 тоот тушаалын дагуу 471 ажилтныг урьдчилан сэргийлэх зорилгоор зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлийн чиглэлээр эмнэлгийн үзлэг шинжилгээнд хамрууллаа.

2024 оны компанийн бизнес төлөвлөгөө, “Хамтын гэрээ”-ний дагуу сувиллын, хоолны үнийн, унааны үнийн, халаалтын улирлын хөнгөлөлтүүд, тэтгэмж, буцалтгүй тусламжийг ажилтны хүсэлтийг үндэслэн тухай бүр олгосон.

Төрийн дээд одон медаль, Засгийн газрын шагнал салбарын тэргүүний ажилтан тэмдэг, жуух бичиг, эрчим хүчний салбарын болон компанийн ажил мэргэжлийн аварга, ҮЭХ, Монголын Залуучуудын холбооны шагнал болон бусад шагналаар 105 ахмад болон ажилтан шагнуулж, 2024 оны компанийн бизнес төлөвлөгөө, “Хамтын гэрээ”-г үндэслэн шагнал урамшууллын зардалд 224.7 сая төгрөг зарцуулсан байна.

Шагнагдсан ахмадууд, ажилтнуудын тоо (2024 он)

Д/д	Шагналын нэр	Төв компани	Хэнтий ЦТСС	Говьсүмбэр ЦТСС	Багануур ЦТСС	Дундговь ЦТСС	Дорноговь ЦТСС	Нийт
1	Аж үйлдвэрийн гавьяат ажилтан	0	0	0	0	0	0	0
2	Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон	5	0	0	0	0	0	5
3	Алтангадас одон	14	0	2	0	0	1	17
4	Хөдөлмөрийн хүндэт медаль	3	0	5	4	1	0	13
5	Эрчим хүчний тэргүүний ажилтан тэмдэг	2	3	0	1	1	0	7
6	Бусад салбарын тэргүүний ажилтан тэмдэг	1	0	0	5	0	1	7

7	Эрчим хүчний яамны "Хүндэт жуух бичиг"	5	0	5	3	1	1	15
8	Бусад яамны "Хүндэт жуух бичиг"	0	8	2	8	0	1	19
9	МЭХГУУЭХ-ны шагнал	0	0	4	8	0	0	12
10	МЗХ-ны шагнал	3	0	2	5	0	0	10
11	Мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан ажилтны тоо	24	24	17	23	12	28	128

Шагнагдсан ахмадууд, ажилтнуудын тоо (2021-2024 он)



2.3. Хүний нөөцийн судалгаа

Компанийн нийт ажилтны 66.1 хувь нь эрэгтэйчүүд байна. Насны бүтцийн хувьд компанийн нийт ажилтны бараг тал хувийг 35-аас доош насныхан бүрдүүлдэг ба дөрвөн ажилтан тутмын гурав нь 45-аас доош насныхан байна. Компанийн ажилтнуудын талаас илүү хувь нь дээд боловсролтой бөгөөд дийлэнх нь монтер, ИТА-ууд байна

Д/д	Үзүүлэлт	Төв компани	Хэнтий ЦТСС	Говьсүмбэр ЦТСС	Багануур ЦТСС	Дундговь ЦТСС	Дорноговь ЦТСС	Нийт
1	Батлагдсан орон тоо	102	116	92	71	77	97	555
	Сул орон тоо	1	0	11	2	1	9	24
	Ажиллаж байгаа нийт ажилтны тоо	101	116	81	69	76	88	531
	Ажиллаж байгаа нийт ажилтнуудаас: Эрэгтэй	59	80	50	51	60	51	351
	Эмэгтэй	42	36	31	18	16	37	180
2	Ажиллаж байгаа нийт ажилтнуудаас: УАТ	14	4	4	4	4	4	34
	ИТА	42	29	26	17	24	22	160
	АХ	18	4	4	5	4	3	38
	БТА	27	79	47	43	44	59	299
3	Жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй ажилтны тоо	4	2	1	5	3	11	26
4	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тоо	4	3	3	1	-	1	12




Компанийн хэмжээнд 288 буюу 55% нь дээд боловсролтой, 84 буюу 16% нь тусгай дунд боловсролтой, 137 буюу 27% нь бүрэн дунд боловсролтой, 12 буюу 2% нь бүрэн бус дунд боловсролтой байна.

Д/д	Боловсрол	Төв компани	Хэнтий ЦТСС	Говьсүмбэр ЦТСС	Багануур ЦТСС	Дундговь ЦТСС	Дорноговь ЦТСС	Нийт
1	Дээд	80	51	34	42	36	51	294
2	Тусгай дунд	1	18	35	4	13	8	79
3	Бүрэн дунд	20	46	9	22	23	29	149
4	Бүрэн бус дунд	0	1	3	1	4	0	9
Нийт		101	116	81	69	76	88	531

Компанийн нийт ажилтны дийлэнх буюу 34 хувийг 18-25 насныхан, 32 хувийг 36-45 насныхан эзэлж байгаа бол үлдсэн 23 хувийг 46 буюу түүнээс дээш насныхан эзэлж байна.

Д/д	Ажилтнуудын насны ангилал	Төв компани	Хэнтий ЦТСС	Говьсүмбэр ЦТСС	Багануур ЦТСС	Дундговь ЦТСС	Дорноговь ЦТСС	Нийт
1	18-25 настай ажилтны тоо	6	12	7	9	7	16	57
2	26-35 настай ажилтны тоо	28	41	23	19	32	36	179
3	36-45 настай ажилтны тоо	44	37	17	21	22	24	165
4	46-55 настай ажилтны тоо	16	21	28	16	12	11	104
5	56-65 настай ажилтны тоо	4	5	3	3	1	0	16
Нийт		101	116	81	69	76	88	531



2.4. Хууль, эрх зүйн чиглэлээр

2.4.1.Хууль, шүүхийн маргааны талаар

Тайлант хугацаанд шийдвэрлэгдсэн компанитай холбоотой дараах шүүхийн маргаанууд байна. Үүнд:

1.“БЗӨБЦТС” ТӨХК-ийн нэхэмжлэлтэй, “Арвис-Интернэшнл” ХХК-нд холбогдох иргэний маргаанд компанийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр шүүхэд төлөөлөн тус компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 3-р баг, Хонхорын 1-р байрны 53 тоот 4 өрөө, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 3-р баг, Хонхорын 8-р байрны 33 тоот 1 өрөө, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 3-р баг, Хонхорын 5-р байрны 03 тоот 1 өрөө орон сууцуудын өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг “Арвис-Интернэшнл” ХХК хууль бусаар өөрийн нэр дээр гаргуулж, тус компанийн өмчлөх эрхэд халдсантай холбоотой иргэний маргаанд Говьсүмбэр аймаг дахь эрүү, иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны нийт 24 удаагийн шүүх хуралд компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн дагуу амжилттай хамгаалж, улмаар Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 001/ШХТ2024/01177 дугаар тогтоолоор дээрх 3 орон сууцыг “БЗӨБЦТС” ТӨХК-ийн өмч болохыг баталгаажуулан зохих шүүхийн шийдвэрүүдийг гаргуулан баталгаажуулж, БЗӨБЦТС ТӨХК-ийн өмчлөлийн эд хөрөнгийг бусдын хууль бус өмчлөлд орохоос хамгаалсан.

2.Иргэн М.Мөнхзулын нэхэмжлэлтэй “БЗӨБЦТС” ТӨХК-нд холбогдуулан цалин, тэтгэврийн зөрүү, сэтгэл санааны хохирол, сар бүрийн тэтгэмжийг нэмэгдүүлэх иргэний хэргийн маргаан нь 2023, 2024 оныг дамжин шүүхээр хянан шийдвэрлэгдэж, Говьсүмбэр аймаг дахь эрүү, иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхээр шийдвэрлүүлж, Улсын дээд шүүхээс уг иргэний хэргийг анхан шатны шүүхээр хянан шийдвэрлүүлэхээр буцаасантай холбогдуулан 2023-2024 онуудад анхан болон давж заалдах шатны нийт 29 удаагийн шүүх хуралд компанийг төлөөлөн оролцож, нэхэмжлэлийн шаардлагаас ний 236.000.000 (хоёр зуун гучин зургаан сая) төгрөгийг хэрэгсэхгүй болгуулан шийдвэрлүүлсэн.

3.Эй уан констракшн ХХК-нд холбогдох болон Хэнтий аймгийн Бэрх тосгонд байрлах тус компанийн үндсэн хөрөнгөтэй холбоотой иргэний маргаанууд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийгдэж байна.

2.4.2.Авлигын эсрэг үйл ажиллагааны талаар

МУ-ын Улсын Их хурлын “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 2024 оны 05-р сарын 16-ны өдрийн 46 дугаар тогтоолын дагуу Эрчим хүчний яамнаас өгсөн чиглэлийн дагуу компанийн Авлигын эсрэг төлөвлөгөөг боловсруулан гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан, гүйцэтгэлийн тайланг хагас, бүтэн жилээр эрчим хүчний яаманд хүргүүлж ажилласан ба компанийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг компанийн bnedo.mn цахим хуудсанд байршуулан иргэд, олон нийтийг танилцах боломжоор хангаж ажилласан. Компанийн 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны ажлын төлөвлөгөөний ажлын тайланг хагас болон бүтэн жилээр гарган ЭХЯ-д хүргүүлж ажилласан.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу АТГ-аас ирүүлсэн 3 удаагийн албан шаардлагын дагуу хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг



авч, холбогдох буруутай ажилтнуудад сахилгын шийтгэл ногдуулж, хариуг тогтоосон хугацаанд АТГ-т хүргүүлж ажилласан.

Компанийн ХЭХ-аар компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан баталсантай холбогдуулан 2024 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор компанийн ХАСХОМ гаргах албан тушаалын жагсаалтыг батлуулан, удирдах албан тушаалд томилогдох албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахимаар хүлээн авч, АТГ-т хүргүүлж, хариуг үндэслэн албан тушаалд томилох шийдвэрийг гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулж ажилласан ба 2024 онд нийт 11 нэр дэвшигчээс ХАСУМ-ийг хүлээн авч, албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор ХАСХОМ-ийг цахимаар хүлээн авч баталгаажуулж ажилласан.

Жил бүрийн 2-р сарын 15-ны өдрийн дотор ХАСХОМ гаргах үүрэг бүхий албан тушаалтнуудаас ХАСХОМ-ийг шинэчлэн авч баталгаажуулах ажлыг зохион байгуулж нийт 42 ажилтнаас хуулийн хугацаанд ХАСХОМ-ийг хүлээн авч баталгаажуулан, Эрчим хүчний яаманд 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдөр ХАСХОМ тайлан, мэдээг нэгтгэн баталгаажуулж цаасаар болон цахимаар гаргаж хүргүүлсэн

2024 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргах үйл ажиллагаатай холбогдуулан АТГ-аас зохион байгуулсан онлайн сургалтуудад хамрагдаж, компанийн ХАСХОМ гаргах үүрэг бүхий албан тушаалтнуудад мэдүүлэг гаргах үйл ажиллагаа, холбогдох хууль, тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт, цахим программд мэдүүлэг гаргаж баталгаажуулах үйл ажиллагаатай холбоотой онлайн сургалтыг 2024 оны 01-р сарын 18-ны өдөр зохион байгуулж мэдүүлэг гаргагч нарыг хамруулсан.

2024 онд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн нийт 92 мэдэгдэл, тайлбарыг холбогдох албан тушаалтнуудаас хүлээн авч, mediuuleg.iaas.mn цахим программд нэг бүрчлэн бүртгэж баталгаажуулсан.

2.5. Сургалтын чиглэлээр

Сургалт хөгжлийн бодлогын зорилго нь компанийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл, хүний нөөцийн бодлого, баримтлах зарчмын хүрээнд байгууллага болон ажилтнуудад шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлон сургалтаар мэдлэг ур чадвар олгох, суралцагч байгууллагын соёл зан үйлийг төлөвшүүлж, үр дүнтэй зохион байгуулж, сургалтын чанарыг тасралтгүй сайжруулан ажилтныг тогтмол хөгжүүлэхэд чиглэгддэг ба компанийн 2023 оны сургалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, нийт ажилтнуудаас авсан санал хүсэлт, судалгаа, эрчим хүчний салбарын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын сургалтын төлөвлөгөө, шаардлагад тулгуурлан 2024 оны сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг боловсруулан гүйцэтгэх захирлаар батлуулж, төлөвлөгөөний дагуу биелэлтийг хангаж ажилласан.

Сургалтын төрөл:

- Мэргэжил дээшлүүлэх буюу давтан сургалт
- Мэргэшүүлэх сургалт
- ХАБЭА-н сургалт
- Ажлын байрны дасгал сургалт

Сургалтыг зардлыг төрлөөр нь ангилвал



2024 онд нийт 1823 цагийн сургалтыг гаднын ААН байгууллага, иргэн, хувь хүмүүсээс авахаас гадна компанийн дотоод нөөц бололцоог ашиглан Монгол Улсын зөвлөх, мэргэшсэн инженер техникийн ажилтан болон албан хаагчид зааж, давхардсан тоогоор 6350 ажилтнуудад зохион байгуулсан. Үүнд:



Албан хаагч 572 (9%)



Инженер техникийн ажилтан 1905 (37,2%)




Бага тушаалын ажилтан 2754 (53,8%)

Сургалтын зардал

2024 оны сургалтын зардлыг 206.72 сая төгрөгөөр төсөвлөж, 153.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Сургалтын зардал (2021-2024 он, сая.төг)





ГУРАВ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

3.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын талаар

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах 4 чиглэлээр 25 ажил төлөвлөснөөс 25 ажил буюу 100% бүрэн хийж гүйцэтгэсэн.

Д/д	Дасгал, зааварчилгааны төрөл				2021 он	2022 он	2023 он	2024 он
1	Зааварчилгаа авсан хүний тоо	Урьдчилсан			124	218	119	121
2		Анхан шатны			97	212	133	140
3		Давтан	Ээлжит	Өдөр тутмын	49175	84229	47252	47841
4				Сарын давтан	4435	4332	2357	2468
5			Ээлжит бус		6136	7374	2505	2487
6		Тухайлсан			10853	12046	12436	12541
7	Дасгал	АЭД	Дасгалын тоо		159	178	57	61
8			Хамрагдсан хүний тоо		2607	2883	520	526
9		ГЭД	Дасгалын тоо		69	88	42	45
10			Хамрагдсан хүний тоо		2423	2617	265	253

ХАБЭА-н III шатны үзлэг шалгалт хийхдээ дасгал, зааварчилгаа чанартай явагдаж байгаад хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулах үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон галын багаж хэрэгслийн норм, ашиглах журам болон ХАБЭА-н ажилтнуудын ажлын байранд хөтлөх журнал, баримт бичгийн жагсаалт, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг шинэчлэн томилох тушаалуудыг батлуулж хэрэгжилтийг хангасан.

ХАБЭА-н зөрчил (салбараар)

Д/д	Салбар	ХМС	Бэлэн байдал	ЗҮЖ	Дүрэм, журам	Нийт
1	Багануур			1	1	2
2	Дундговь				1	1
3	Дорноговь	2			2	4
4	Говьсүмбэр			3		3
5	Хэнтий	1	2		3	6
6	Компани	1	1	2	1	5
Нийт		4	3	6	8	21

ХАБЭА-н зөрчил (2020-2024 он)

Д/д	Салбар	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
1	Багануур	2	1	4	3	2
2	Дундговь	3	0	3	3	1
3	Дорноговь	0	2	3	4	4
4	Говьсүмбэр	1	2	4	4	3
5	Хэнтий	5	6	9	3	6
6	Компани	1	0	2	0	5
Нийт		12	11	25	17	21

Компанийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин механизмын ашиглалтын түвшин тогтоох, ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэг, шалгалтыг зохион байгуулах “Үзлэг шалгалт хийх журам”-ын хэрэгжилтийг ханган үзлэг шалгалт хийсэн ажлын дүн:

2024 оны ХАБЭА-н III шатны болон АТТ үзлэгийн нэгдсэн дүн

2025 оны 02 дугаар сарын 24

Багануур дүүрэг

Д/д	Салбар	Илэрсэн гэмтэл	Устгасан гэмтэл	Үлдсэн гэмтэл	Гүйцэтгэл
1	2	4	5	6	7
1	Говьсүмбэр	258	258	0	100
2	Дорноговь	429	404	25	94.2
3	Дундговь	213	209	4	98.1
4	Багануур	355	348	7	98.0
5	Хэнтий	615	480	135	78.0
Нийт		1870	1699	171	90.9

Компанийн хэмжээнд тоног төхөөрөмжийн ашиглалтын түвшнийг тогтоох ээлжит үзлэгийг 2024 оны 2 дугаар улиралд Дундговь, Хэнтий, Багануур, Говьсүмбэр, Дорноговь салбарын эзэмшлийн дэд станц, шугам тоноглолд нэг удаа зохион байгуулж, илэрсэн гэмтэл зөрчлийг устгах хугацаатай үүрэг даалгавар өгч, салбаруудын хийсэн ажлын гүйцэтгэлийг зургаар баталгаажуулан авч ажилласан ба ЭХЯ-4, ХАБЭАХ-6 ШҮГХ-5 нийт 15 сэрэмжлүүлэг,мэдээлэл даалгаврыг харьяа салбарууд болон хэлтэс албадуудад хүргүүлж хэрэгжилтийг хангуулан тайлан заасан хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

2024 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 6 албан тушаалын ажлын байруудад 8 ажилтныг оролцуулан хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэж, 2023 онд урьдчилсан

байдлаар хэвийн бус үнэлэгдсэн байцаагч монтер, дуудлагын монтерын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл хэвийн бус нөхцөлөөр баталгаажсан.



Компанийн хэмжээнд мэдрэгчтэй касканы судалгааг гаргаж, бүх каскануудын хүчдэл мэдрэгчид үзлэг хийж, мэдрэгчгүй болон батарей дууссан мэдрэгчийг олгох ажлыг зохион байгуулсан.



Компанийн үйлчлэх хүрээний өөрийн эзэмшлийн болон хэрэглэгчийн эзэмшлийн дэд станц, дэд өртөө, хуваарилах байгууламж, цахилгаан дамжуулах агаарын шугамд үзлэг үйлчилгээ, сэлгэн залгалт, гэмтэл устгах ажлын үед хийгдэж буй үйлдлийг хянах, нотлох баримтыг бэхжүүлэх, дууны, дүрсний, дуу дүрсний бичлэг хийх, гэрэл зураг авах аргыг хэрэглэж, ажилтнуудын ажил үүргийн чанарыг сайжруулах, болзошгүй зөрчил, маргаан үүссэн тохиолдолд нотлох баримтыг бий болгох зорилгоор энгэрийн камерыг энэ оноос эхлэн ашиглаж байна.



Ажилтнуудын аюулгүй ажиллагааг хангах зорилгоор эрсдэл өндөртэй ажлын байр, олон талын тэжээлтэй, тойрог схемтэй дэд станцуудын ажлын байр бэлтгэх, сэлгэн залгалтын үйлдэл хийх үеийн аюулгүй ажиллагааг дээшлүүлэх, таслах залгах аппаратууд ба энергийн бүх төрлийн нөөцийг санамсаргүйгээр залгагдах, тоноглол хүчдэлтэй болох, машин тоног төхөөрөмж ажиллахаас сэргийлэх зорилгоор компанийн хэмжээнд цоож пайзны системийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Компанийн хэмжээнд ХЭМАБ-н менежментийн тогтолцоог нэвтрүүлэн ажиллах зорилтыг тавьж, ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлж, хөдөлмөрийн нөхцөлөөс шалтгаалсан осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй сайжруулах үүргийг хүлээн ажиллаж байна. Мөн компанийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үйл ажиллагааны мэдээллийг цаг алдалгүй солилцож, мэдээний санд тулгуурлаж тайлан боловсруулж, үр дүнгийн боловсруулалтад

дүн шинжилгээ хийх боломжтой программ хангамж нэвтрүүлэх зорилгоор ХАБЭА-н программыг ашиглалтад оруулах ажил хийгдэж байна.



БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 01/312

Улаанбаатар хот

Компанийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх хамрах хүрээг батлах тухай.


“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй”-н тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 28.1.6 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

- 1.Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны олон улсын ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх зорилгоор компанийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлогыг хавсралтаар баталсугай.
- 2.Компанийн хэмжээнд ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх хамрах хүрээг Төв компани болон Багануур цахилгаан түгээх сүлжээ салбарт хэрэгжүүлэхээр тогтоосугай.
- 3.Компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлогыг нийт ажилтнууд болон сонирхогч талуудад танилцуулж нийтэд нээлттэй байлгах, шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг ISO 45001:2018 Менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх ажлын хэсэг (А.Азбаяр)-т үүрэг болгосугай.
- 4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга (Д.Цэцгээ)-д үүрэг болгосугай.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.МӨНГӨНХӨЛӨГТ



“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын ажлын 10 сарын 24 өдрийн 01/312 тоот тушаалын хавсралт

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН БОДЛОГО

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК нь Монгол улсын хуулийн хүрээнд ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангаж, ажилчдыг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарахаас урьдчилан сэргийлж, хөдөлмөрийн чадвар алдалтгүй ажиллахыг зорин. Компанийн ажилтнууд болон оролцогч бусад талуудтай зөвлөлдөх замаар хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал (“ХЭМАБ”)–ын менежментийн тогтолцоог нэвтрүүлж, тасралтгүй сайжруулан, аюулгүй ажиллагааны соёлыг хөгжүүлэн, төлөвшүүлэхэд бидний зорилго оршино.

Үүний тулд:

1. Компанийн ажилтнуудын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлүүдийг үнэлж, тэдгээрийг бууруулах, хянах арга хэмжээ тогтмол авч хэрэгжүүлэх;
2. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг дагаж мөрдөх тэдгээрийн хэрэгжилтийг биелүүлэхийн төлөө эрмэлзэн ажиллах;
3. ХАБЭА-н зорилго, зорилт болон гүйцэтгэлтэй холбоотой хариуцлагын асуудлыг байгууллагын бүх төвшинд бий болгож, мэдээллийг шуурхай солилцох;
4. Нийт ажилтнуудад аюулгүй ажиллагааны мэдлэг олгох үр чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв хандлага соёлыг төлөвшүүлэх;
5. ХАБЭА-н зөрчил, үйлдвэрлэлийн ослын шууд болон суурь шалтгаануудыг тогтоож, дахин давтагдахаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллах;
6. Менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулах зорилгоор ажлын гүйцэтгэлийн үр дүнгийн талаар тогтмол хяналт тавих, дотоод болон хөндлөнгийн аудит хийх, илэрсэн үр дүнгээр нэмэлт арга хэмжээг тус тус авч ажиллана.

ЭНЭХҮҮ БОДЛОГО НЬ БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН АЖИЛТНУУДАД БОЛОН ТҮҮНИЙ СОНИРХОГЧ ТАЛУУДАД ХАМААРАХ БӨГӨӨД НИЙТЭД НЭЭЛТЭЙ БАЙНА.



МУЗГ, ЭХЯ болон мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу тухай бүр нь авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган батлуулан ажил зохион байгуулан мэргэжлийн байгууллагаас өгч буй зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан. 2024 онд гамшгаас хамгаалах үзлэгт амжилттай хамрагдсан ба Гал унтраах шуурхай төлөвлөгөөг шинэчлэн гаргаж батлуулан ажилласан.

Харьяа салбаруудаас гамшгийн хамгийн эрсдэл өндөртэй болох Хэнтий цахилгаан түгээх сүлжээ салбарын ажилтан, техник тоног төхөөрөмж, барилга байгууламжид тохиолдож болзошгүй гамшгийн эрсдэлийг тодорхойлох, түүнийг бууруулах үйл ажиллагааг

төлөвлөх зорилгоор “Дат консалтинг” ХХК-тай хамтран Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийлгэн онцгой байдлын ерөнхий газарт хянуулан баталгаажуулахаар өгөөд байна.

2024 онд Компанийн хэмжээнд эрүүл ахуйн чиглэлээр нийт 471 ажилтныг урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгийн Улаанбаатар хотод “Манчим” ХХК-тай гэрээ байгуулан хамруулан ажилласан.


3.2. Мэдлэгийн сургалт, шалгалтын талаар

2024 оны ээлжит мэдлэгийн шалгалтын тестийг “Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед ажиллах аюулгүй ажиллагааны дүрэм”, “Нэгдсэн сүлжээний дүрэм”, “Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрэм”, “Нэгдсэн сүлжээнд гарсан аваар устгах болон цахилгааны хуваарилах байгууламжид сэлгэн залгалт хийх заавруудын эмхэтгэл”, “Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм”-ийн хүрээнд боловсруулж “MY TEST” программ ашиглан авч ажилласан.



2024 ОНЫ ЭЭЛЖИТ МЭДЛЭГИЙН ШАЛГАЛТЫГ “MY TEST”
ПРОГРАММ АШИГЛАН АВЧ АЖИЛЛАСАН.

ХАБЭАХ



ӨЗММ-тай аюулгүй ажиллах талаар мэргэжлийн сургалтын төвөөс сургалт авч ажилласан.





ДӨРӨВ. ЦАХИЛГААН ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

4.1. Техникийн нөхцөл олголтын талаар:

Техникийн нөхцөл олголтыг хэрэглэгчдийн хэрэглээний шинж чанар, ачааллын хэмжээ, хүчин чадлыг судалж, түгээх сүлжээний хүчин чадал, техникийн боломжийг харгалзан орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хэрэглэгчийн шугам сүлжээ, дэд станцуудыг угсруулах, модон тулгууруудыг төмөр бетон тулгуураар солих шаардлагад нийцүүлэн олгож байна. Үүнд: Тосон таслууруудыг вакум болон элегаз, реклоузер таслуураар солиулж микропроцессорын хамгаалалттай болгох найдвартай ажиллагааг хангах түгээх сүлжээний алдагдлыг бууруулах зорилгоор хүчний трансформаторуудыг хамгийн ашигтай горимоор ажиллаж байхаар, алдагдал багатай хүчний трансформатор тавих, аюулгүй ажиллагааны үүднээс хот, төв суурин газруудад КТПН, хаалттай хуваарилах байгууламж барих зэрэг шаардлагуудыг хэрэглэгчдэд тавин ажиллаж байна.


Компанийн эзэмшлийн 6-35 кВ-ын хүчдэлийн түвшинд цахилгаан эрчим хүчинд холбуулахаар 191 хэрэглэгч техникийн нөхцөл хүссэн албан хүсэлт ирүүлснээс 183 хэрэглэгч буюу шинээр 52.1 МВА суурилагдсан хүчин чадал бүхий техникийн нөхцөл олгож 36,750,000.00 төгрөг компанид төвлөрүүлснээс 2024 оны байдлаар 6-35 кВ-ын нийт олгогдсон техникийн нөхцөлийн 64 хэрэглэгчийн 22.3 МВА суурилагдсан чадалтай хэрэглээ эрчим хүчний системд холбогдоод байна.

Техникийн нөхцөл олголтын судалгаа 2023-2024 он

Д/д	Салбарын нэр	Техникийн нөхцөлийн хүсэлт	Олгосон			Олгоо-гүй	Техникийн нөхцөлийн хүсэлт	Олгосон			Олгоо-гүй
			Тоо	Үүнээс салбарт	Чадал МВА			Тоо	Үүнээс салбарт	Чадал МВА	
		2023 он						2024 он			
1	Багануур	28	28	2	2.9	0	40	40	5	12.1	0
2	Говьсүмбэр	39	36	5	9.9	3	31	26	1	7.4	5
3	Дорноговь	44	41	9	10.8	3	32	30	2	9.8	2
4	Дундговь	20	19	7	3.5	1	29	28	7	7.4	1
5	Хэнтий	44	42	3	10.6	2	59	59	6	15.2	0
Нийт		174	165	26	38	9	191	183	21	52.1	8


Хэрэглэгчид хэрэглээнийхээ чадлыг буруу тооцоолсноос дэд станцуудын чадал өндөр тавигдаж, анх захиалсан эрчим хүчээ авахгүй байдал бий болж байна. Иймээс хэрэглэгчид тохирсон хүчин чадлыг сонгох бусад заавар зөвлөмжүүдийг өгч ажиллалаа. Техникийн нөхцөлийн дийлэнх буюу 45 хувийг 6 кВ-ын техникийн нөхцөл олголт эзэлж байна.

Техникийн нөхцөлийн олголтын суурилагдсан чадал (МВА) судалгаа



Техникийн нөхцөл олголтын тоо, чадлын хэмжээ

Д/д	2023 он			
	Техникийн нөхцөлийн хүсэлт	Олгосон		Олгоогүй
		Тоо	Чадал МВА	
Багануур	28	28	2.9	0
Говьсүмбэр	39	36	9.9	3
Дорноговь	44	41	10.8	3
Дундговь	20	19	3.5	1
Хэнтий	44	42	10.6	2
Нийт	174	165	38	9



2024 онд хийгдэх их засварын 28, ТЗБАХ-ний 40 ажил дээр зургийн дагуу ажлын эзлэхүүнийг тодорхойлж, эрчим хүчний барилга угсралтын ажлын төсвийг “Эрчим хүчний үйлдвэр компаниудын засварын ажлын төсөв бодох аргачлал”-ын дагуу, барилга байгууламжийн засварыг “Монгол улсын БХБ Сайдын 142 дугаар тушаалаар батлагдсан “Барилга сантехникийн ажлын төсвийн суурь норм”-ын үнэлгээ, БХБ-ын сайдын 2020 оны 30 тоот тушаалаар батлагдсан, “Барилгын төсөв зохиох /БНБД 81-95-12*2020/ дүрэм”, цалингийн зардлыг БХБ-ын сайдын 2020 оны 30 тоот тушаалын 3 дугаар хавсралт, машин механизмын зардлыг “ЗТБХБ-ын сайдын 2012 оны 18 дугаар тушаал/БД81-112-11/”, тээврийн зардлыг “ЗТХ-ийн Сайдын 2019-07-31-ний өдрийн 256 тоот тушаалын 4 дүгээр хавсралт”-аар батлагдсан жишиг тариф, орон нутгийн материалын тээврийн зайг 1986 оны “БАТУХ-ны 7 дугаар тогтоол, захиалагчийн өгсөн зай (км)”-г баримтлан тооцож байна.

Материалын үнийг “Барилгын мэдээлэл сэтгүүл”, барилгын үнэ ханшийн мэдээллийн сайтууд, харьяа салбаруудаас ирүүлсэн ажлын эзлэхүүнийг үндэслэн засварын инженерүүдийн гаргаж өгсөн зургийн дагуу зах зээл дээр худалдаалагдаж байгаа үнийн судалгаа ашиглан дундаж үнийг тогтоосон болно.

Бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын төсвийг Барилгын төсөв зохих дүрмийн дагуу хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Дорноговь аймаг, Хатанбулаг сум, Ханги боомт дахь олон төрөлт чингэлэг тээврийн терминалын гадна цахилгаан хангамжийн барилга угсралтын ажлын төсөв

2.Багануур дүүргийн орон сууцны хороолол барих гадна цахилгаан хангамжийн 2*800 кВА ХТП

3.РП, ТП-ны төсөв

Инфляци 2024 оны 4 дүгээр улиралд дунджаар 7.5 хувьд хүрсэн, үүнээс импортын бараа бүтээгдэхүүний өсөлт 2.2 хувийг эзэлж байгаа, мөн 2025 онд инфляци 8.8 хувьд хүрэх Төв банкны урьдчилсан судалгааг үндэслэн эрчим хүчний барилга угсралтын ажлын төсвийг зохиохдоо үнийн өсөлтийг материалын зардлыг 2,5 хувиар өсгөж бодож гаргасан.

4.9. Стандарт, судалгааны ажлын чиглэлээр

Компанийн хэмжээнд:

- Цахилгаан дамжуулах шугам, тоноглол, тоног төхөөрөмжийн талаар 28 стандарт
- Барилга байгууламжийн 7 стандарт
- Тээврийн хэрэгслийн 7 стандарт
- Мэдээлэл холбооны 9 стандарт
- Бусад чиглэлээр 3 стандарт, тус тус нийт 54 стандартыг мөрдөж ажиллаж байна.

2024 оны эхний 09 сарын байдлаар компанийн хэмжээд гарсан нийт тасралтын судалгаа гаргаж, хамгийн олон тасарсан шугам тоноглолын ашиглалтыг дээшлүүлэх зорилгоор 2025 оны Их засвар, ТЗБАХ-ийн төлөвлөгөөнд тусгуулж ажиллав.

Мөн жил бүр насжилтын судалгааг салбаруудаас авч нэгтгэн, дэд станц, агаарын шугам, кабель шугам, хуваарилах байгууламж тус бүрээр судалгаа гаргаж байна.

2024 онд “ЭХЭЗХ”, “ЭХЗХ”, “Монхорус Интернэшл ХХК” газруудаас ирүүлсэн албан бичгийн дагуу дараах стандартуудад санал хүргүүлж ажилласан. Үүнд:

1. IEC 61439 “Нам хүчдэлийн хуваарилах байгууламж болон удирдлагын тоноглолын иж бүрдэл”



2. MNS 5872:2019 “Цахилгаанаар хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага”
3. IEC 60598-1:2020
4. MNS IEC 61850-90-12
5. СИП дамжуулагчтай 2 хүчдэлийн түвшний цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр бетон тулгуур угсарч босгох ажлын технологийн карт
6. Бүрээстэй дамжуулагчтай 35 кВ-ын УКШ-12 маркийн тулгуур угсарч босгох ажлын технологийн карт, стандарт.

Гүйцэтгэх захирлын 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/207 тоот тушаалаар Стандарт, судалгааны инженерийн орон тоо шинээр нэмэгдсэнээр менежментийн хувьд мэргэжлийн ИТА нарын орон тоо нэмэгдэж, ачаалал тэнцвэржиж байна.

Мөн уламжлалт технологиос татгалзаж сүүлийн үеийн ухаалаг сүлжээ, системүүд, хиймэл оюун ухаан ашигласан технологийн боломжуудыг судлуулах, инноваци, бодит судалгаанд үндэслэн түгээх сүлжээний үр ашгийг нэмэгдүүлэх хэтийн бодлого, техникийн шинэчлэлийг төлөвлөх зорилтын үүднээс гадаад хэлнээс орчуулга судалгааг хийж гарын авлага болгон бэлтгэж байна.

4.10. Шуурхай ажиллагааны чиглэлээр

4.10.1. Сургалт, дасгал, зааварчилгааны талаар

Шуурхай ажиллагааны шинэчлэгдсэн дүрэм, журам, заавраар ээлжит бус сургалт, ТАД, нэгдсэн сүлжээнд гарсан аваар устгах болон цахилгаан хуваарилах байгууламжид сэлгэн залгалт хийх заавруудын эмхэтгэлээр салбар болон компанийн ажиллагсад, шуурхай ажиллагааны чиглэлээр нийт 40 цагийн сургалт зохион байгуулж ажилласан.

Шинэ тоног төхөөрөмж ашиглалтад хүлээн авах, шинээр ажилд орж байгаа болон сарын хугацаатай ажлаас хөндийрсөн ажилтан, ажлын байр өөрчлөгдсөн ажилтан, ажлын явцад аюулгүй ажиллагааны аливаа дүрмийн зөрчил дутагдал, гарч болох аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны анхан болон ээлжит бус зааварчилгааг 22 удаа явуулж, хэлтсийн шуурхай ажиллагааны бүх ажилтнууд хамрагдсан.

Шуурхай үйлчилгээ горимын хэлтэст Говьсүмбэр салбараас 11, Хэнтий салбараас 12, Багануур салбараас 3, нийт 25 ажилтан дагалдуулан сургаж, сэлгэн залгалт хийх, шуурхай ажиллагаа явуулах эрх олгосон.

Аваар эсэргүүцэх дасгалыг төлөвлөгөөний дагуу улирал бүр зохион байгуулж ирсэн. Мөн төлөвлөгөөт бус байдлаар компанийн удирдлагын шийдвэрээр 4 удаа компанийн хэмжээнд II/08, V/18, VIII/10, XII/05-ний өдрүүдэд АЭД-г зохион байгуулж, харьяа салбаруудад дэд станц бүрээр сэдэв гарган өгч гүнзгийрүүлсэн байдлаар зохион байгуулсан. Мөн ДҮТ ТӨХХК-с зуны бага ачааллын горим, өвлийн их ачааллын горимд шилжсэнтэй холбогдуулан Нэгдсэн сүлжээний хэмжээнд аваар эсэргүүцэх дасгалыг дасгалыг 2024 оны 06 дугаар сарын 05, 09 дүгээр сарын 29-ний өдрүүдэд зохион байгуулж явуулсантай уялдуулан нэмэлт сэдэв боловсруулан “Гүнзгийрүүлсэн” хэлбэрээр зохион байгуулж, бие дааж аваар устгах чадвар, аваарын бэлэн байдлыг шалгасан ба дасгалын үед гарсан алдаа дутагдлыг арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгч төлөвлөгөө гаргуулан, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

4.10.2. Шинэ хэрэглэгчийн судалгаа

2024 онд сүлжээнд холбогдсон 0.4-35 кВ-ын шинэ хэрэглэгч тоо (сараар)

Сар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Нийт
2020	11	10	5	25	26	35	37	16	35	38	18	11	267
2021	6	6	6	11	22	40	41	22	49	54	26	20	303
2022	0	0	3	24	17	32	25	16	40	49	25	4	241
2023	0	3	6	17	32	13	22	27	27	72	54	12	285
2024	10	6	3	18	27	36	38	30	77	138	57	21	461

2020-2024 оны 6-35 кВ-ын шинэ хэрэглэгчийн тоо (салбараар)

Д/д	Салбарын нэр	Он				
		2020	2021	2022	2023	2024
1	2	3	4	5	6	7
1	Хэнтий	2	16	22	26	26
2	Дорноговь	5	2	10	16	12
3	Багануур	6	13	9	9	13
4	Говьсүмбэр	8	6	10	7	11
5	Дундговь	1	5	3	5	2
Нийт		22	42	54	63	64

2024 оны шинэ хэрэглэгч (салбар, хүчдэлийн түвшин болон чадлаар)

Салбар	35 кВ	15 кВ	10 кВ	6 кВ	0.4 кВ	Чадал кВт (нийт)
1	2	3	4	5	6	7
Багануур	0	0	490	1418	85	1993
Говьсүмбэр	3080	0	580	1450	1549.6	6659.6
Хэнтий	1960	2340	1440	2805	1811.64	10356.64
Дорноговь	0	0	5650	0	1210	6860
Дундговь	0	63	0	250	1840	2153
Чадал кВт (нийт)	5040	2403	8160	5923	6496.24	28022.24

2024 оны шинэ хэрэглэгч (0.4 кВ)

Он	Говьсүмбэр	Хэнтий	Багануур	Дундговь	Дорноговь	Нийт
1	2	3	4	5	6	7
2020	32	57	36	11	98	234
2021	68	79	39	27	43	256
2022	51	67	13	15	41	187
2023	30	87	7	25	73	222
2024	62	136	26	82	88	394


2024 оны хэрэглэгчдийн тоон судалгаанаас үзвэл нийт 461 шинэ хэрэглэгч холбогдож 2023 онтой харьцуулахад өмнөх оноос 176-р нэмэгдсэн үзүүлэлттэй, компанийн хэмжээнд суурилагдсан чадал 2023 оны эцсийн байдлаар нийт 145.9 МВА байсан бол 2024 онд 18.8 МВА-р нэмэгдэж 164.7 МВА болж өссөн.

4.10.3. Захиалгат ажил




2024 онд хийгдсэн захиалгат ажлын тоо (төрөл болон салбараар)

Д/д	Захиалгат ажлын төрөл	БН	ХЭ	ГС	ДУ	ДО	Нийт
1	2	3	4	5	6	7	8
1	Төлөвлөгөөт	192	448	357	464	278	1739
2	Төлөвлөгөөт бус	4	41	0	48	21	114
3	Аваар	237	373	441	235	227	1513
4	Хэрэглэгч	124	286	350	120	191	1071
5	Нийт	557	1148	1148	867	717	4437



Сүүлийн 5 жилийн захиалгат ажлын тоо

Захиалгат ажил нийт дүнгээрээ 2023 оны захиалгат ажлаас 2.7%-р буурсан боловч мөн өмнөх онуудаас захиалгын тоо 9.4-47.8%-р нэмэгдсэн бол төлөвлөгөөт бус захиалгат ажлын тоо буурсан үзүүлэлттэй харагдаж байна.



Захиалгын тоо 4, 5, 9, 10 саруудад өндөр байгаа нь 2024 онд Дорноговь, Хэнтий, Говьсүмбэр, Дундговь аймгийн нутгаар зун, намрын саруудад дуу цахилгаантай бороо орж үеэр буух үзэгдэл их байснаас аваарын захиалгаар хийгдэх ажлын тоо хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалсан.


ТАВ. ЦАХИЛГААНААР ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

5.1. Худалдан авсан цахилгаан эрчим хүч


Цахилгаан эрчим хүчээр зохицуулалттай хангах, цахилгаан эрчим хүчийг түгээх тусгай зөвшөөрлийн эрх үүргийн хүрээнд “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-иас 2024 онд 683.8 сая кВт*ц цахилгаан эрчим хүчийг худалдан авсан. Өмнөх оноос 50.2 сая кВт*ц буюу 7.3%-иар, 2024 оны төлөвлөгөөнөөс 53.7 сая.кВт.ц буюу 8.5%-иар өссөн.

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги хилийн боомтоор БНХАУ-аас 2024 онд 2.8 сая.кВт*ц цахилгаан эрчим хүчийг импортоор худалдан авсан. Өмнөх оноос 0.7 сая.кВт.ц-аар буюу 35.3%-иар, төлөвлөгөөнөөс 0.4 сая.кВт.ц-аар илүү буюу 1.34%-иар өссөн.

ХАЦЭХ–ний төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулалт, сая.кВт*ц /ДҮТ ТӨХХК/



ХАЦЭХ–ний төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулалт мян.кВт*ц /Импорт/



Худалдан авсан цахилгаан эрчим хүчний хэмжээ өсөхөд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Компанийн сүүлийн 5 жилийн худалдан авсан цахилгаан эрчим хүчний хэмжээ дунджаар 11.8 хувийн өсөлттэй байна. 2020 онд 439.97 сая кВт*цаг байсан бол 2024 онд 683.8 сая кВт*цаг болж 243.8 сая кВт*цаг буюу 55.4 хувиар өссөн байна.
- Хэрэглэгчдийг ангилан үзэхэд 80.9%-ийг уул уурхайн олборлох баяжуулах үйлдвэр болон бусад аж ахуй нэгж байгууллагууд эзлэж байна. Айл өрхийн хэрэглээ 19.1%-ийг эзэлдэг. Хэрэглэгчдийн тоо 2024 онд 55950 хүрч өнгөрсөн оноос 2683 хэрэглэгчээр буюу 5.0%-иар өссөн байна.



- Томоохон хэрэглэгчид болох уул уурхай, олборлох үйлдвэрүүдийн хэрэглээ компанийн нийт хэрэглээний 50-60 хувийг эзэлдэг. Томоохон хэрэглэгчдийн хэрэглээ жил бүр өсөлттэй байгаа учир ХАЦЭХ-ийн өсөлтөд шууд нөлөөлж байна.
- Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Нийслэлийн болон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын хоёр тарифт тоолууртай өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тариф болон сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифын хөнгөлөлт үзүүлж байгаатай холбогдуулан 1,2,3,11,12 саруудад гэр хорооллын айл өрхийн хэрэглээ өсөлттэй байна.


Хэрэглээний өсөлтийг хүснэгтээр харуулвал:

Д/д	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Уул уурхайн хэрэглэгчид					
1	Дөл түшиг ХХК	сая.кВт.ц	5.92	10.05	4.12
2	Багануур ХК	сая.кВт.ц	26.86	27.83	0.97
3	Олон Ихт Баян ХХК	сая.кВт.ц	15.50	16.77	1.27
4	Флюорит ланд фактори	сая.кВт.ц	1.55	2.58	1.03
5	Лут чулуу	сая.кВт.ц	1.40	3.57	2.17
6	Си Эм Кэй Ай ХХК	сая.кВт.ц	6.50	7.51	1.01
7	Хөөт ХХК	сая.кВт.ц	0.67	1.48	0.81
8	Жэй Эм Си прожектс ХХК	сая.кВт.ц	0.64	1.54	0.90
9	бусад уул уурхай	сая.кВт.ц	167.87	178.08	10.22
Нийт		сая.кВт.ц	226.90	249.40	22.50
Бусад аж ахуй нэгж байгууллагын хэрэглэгч					
1	Цэцэнс майнинг энд энерги ХХК	сая.кВт.ц	-	2.66	2.66
2	МАК ХХК	сая.кВт.ц	96.07	100.54	4.47
3	Монцемент ХХК	сая.кВт.ц	17.63	23.25	5.62
4	Төсвийн байгууллага	сая.кВт.ц	30.56	32.50	1.93
5	Бусад ААНБ	сая.кВт.ц	108.74	113.24	4.50
Нийт		сая.кВт.ц	253.01	272.19	19.18
Айл өрхийн хэрэглэгч					
1	Орон сууц	сая.кВт.ц	39.66	40.62	0.95
2	Гэр хороолол	сая.кВт.ц	74.58	82.66	8.08
Нийт		сая.кВт.ц	114.24	123.28	9.04

5.2. Борлуулсан цахилгаан эрчим хүч


2024 онд 644.67 сая кВт*цаг цахилгаан эрчим хүч хэрэглэгчдэд борлуулж өнгөрсөн жилээс 74.16 сая кВт*цаг буюу 13.0 хувиар, төлөвлөгөөнөөс 53.69 сая кВт*цаг буюу 8.52 хувиар тус тус өссөн байна. Сүүлийн 5 жилд дунджаар 512.6 сая кВт*цаг цахилгаан эрчим хүч борлуулж хэрэглээний өсөлт 10.9 хувь байна.

Борлуулсан ЦЭХ /ДҮТ ТӨХХК/



Импортоор 2024 онд төлөвлөгөөгөөр 2,052.5 мян. кВт*ц цахилгаан эрчим хүч борлуулахаас тайлант хугацаанд 2,319.5 мян.кВт*ц буюу батлагдсан төлөвлөгөөнөөс 267.0 мян.кВтц буюу 13.0% -иар өссөн үзүүлэлттэй байна.

Борлуулсан ЦЭХ /Импорт/



5.3. Цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдал

2024 оны гүйцэтгэлээр түгээлтийн алдагдал 5.73 хувь биетээр 39.20 сая кВт*ц байгаа нь төлөвлөгөөнөөс 0.01 нэгжээр, өмнөх оны гүйцэтгэлээс 0.78 нэгжээр буюу биетээр 0.56 сая кВт*ц-аар буурсан байна.

Алдагдлыг бууруулахаар Багануур ЦТС салбарын Мөнгөнморьт суманд 230 ширхэг ухаалаг тоолуур, Нарийн нуурт 90 тоолуур 60 щит мөн Дорноговь ЦТС салбарт 739 ширхэг тоолуур тус тус солих ажлууд хийгдсэн. Хэнтий ЦТС салбарын Хэрлэн суманд 1442 цэгт тоолуур нэгтгэлийн хайрцаг суурилуулсан, 6 кВ-ын ЦДАШ-25.71 км, аж ахуйн нэгжийн тоолууржуулалт-608 ширхэг, айл өрхийн тоолууржуулалт-5607 ширхэг, 0.4 кВ-ын цахилгаан дамжуулан кабель шугам-2.271 км, 6 кВ-ын цахилгаан дамжуулах шугам -1.822 км, хуучин шугам буулгах ажил-100 км төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн. Нийт худалдан авсан цахилгаан эрчим хүчний 6.53 хувийг буюу 40.0 сая кВт*ц-ийг түгээлтийн алдагдалд тооцож, төлөвлөгөөнөөс 1.0 нэгжээр бууруулсан.

- Эрчим хүчний зохицуулах хорооны Зохицуулагчдын зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 537 дугаар тогтоолоор баталсан цахилгаан




- түгээлтийн алдагдал буюу "ДҮТ" ТӨХХК-иас худалдан авсан ЦЭХ-ний түгээлтийн алдагдал 6.52 хувийн гүйцэтгэлтэй, төлөвлөгөөнөөс 0.99 нэгжээр,
- Импортын ЦЭХ-ний түгээлтийн алдагдал 10.27 хувийн гүйцэтгэлтэй, төлөвлөгөөнөөс 5.57 нэгжээр тус тус буурсан.

2024 оны гүйцэтгэлээр түгээлтийн алдагдал 5.73 хувь биетээр 39.20 сая кВт*ц байгаа нь төлөвлөгөөнөөс 0.01 нэгжээр, өмнөх оны гүйцэтгэлээс 0.78 нэгжээр буюу биетээр 0.56 сая кВт*ц-аар буурсан байна.

Алдагдлыг бууруулахаар Багануур ЦТС салбарын Мөнгөнморьт суманд 230 ширхэг ухаалаг тоолуур, Нарийн нуур хэсэгт 90 тоолуур 60 щит мөн Дорноговь ЦТС салбарт 739 ширхэг тоолуур тус тус солих ажлууд хийгдсэн. Хэнтий ЦТС салбарын Хэрлэн суманд 1442 цэгт тоолуур нэгтгэлийн хайрцаг суурилуулсан, 6 кВ-ын ЦДАШ-25.71 км, аж ахуйн нэгжийн тоолууржуулалт-608 ширхэг, айл өрхийн тоолууржуулалт-5607 ширхэг, 0.4 кВ-ын цахилгаан дамжуулан кабель шугам-2.271 км, 6 кВ-ын цахилгаан дамжуулах шугам -1.822 км, хуучин шугам буулгах ажил-100 км төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн.

Алдагдлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулалт



5.4. Цахилгаан эрчим хүчний авлага


Д/д	Ангилал	Хэмжих нэгж	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
1	Төсөв	сая.төг	0	0	0	0	0
2	ҮААГ	сая.төг	114.7	210.9	897.1	1778.3	1644.7
3	Уул уурхай	сая.төг	680.7	580.3	1783.9	1189.6	961.7
4	Айл өрх	сая.төг	128.5	199.7	0	0	0
5	Нийт	сая.төг	923	990.9	2681.1	2967.9	2606.4

Нийт авлагын үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага 1644.7 сая төгрөг буюу 63.1 хувийг, уул уурхай 961.7 сая төгрөг буюу 36.9 хувийг тус тус эзэлж байна.




5.5. Хэрэглээний бүтэц

2024 оны байдлаар уул уурхайн олборлох, баяжуулах үйлдвэр нийт хэрэглээний 38.7 хувь, бусад аж ахуй нэгж байгууллага 37.2 хувь, төсвийн байгууллага 5.0 хувь, орон сууцны айл өрхийн хэрэглээ 6.3 хувь, гэр хорооллын айл өрхийн хэрэглээ 12.8 хувийг эзэлж байна.



Уул уурхайн хэрэглээ 2023 онд 233.98 сая.кВт*ц байсан бол 2024 онд 249.40 сая.кВт*ц буюу 6.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Бусад аж ахуй нэгж байгууллагын хэрэглээ 2023 онд 208.82 сая.кВт*ц байсан бол 2024 онд 239.69 сая.кВт*ц буюу 14.8 хувиар өссөн. Төсвийн байгууллага 2023 онд 28.15 сая.кВт*ц байсан бол 2024 онд 32.50 сая.кВт*ц буюу 5.0 хувиар өссөн. Орон сууцны айл өрхийн хэрэглээ 2023 онд 36.93 сая.кВт*ц байсан бол 2024 онд 40.62 сая.кВт*ц буюу 10.0 хувиар өссөн. Гэр хорооллын айл өрхийн хэрэглээ 2023 онд 62.63 сая.кВт*ц байсан бол 2024 онд 82.46 сая.кВт*ц буюу 31.7 хувийн өсөлттэй байна.


Хэрэглээний бүтэц /хэрэглэгчийн ангиллаар/





5.6. Хэрэглэгчийн тоо

2024 онд хэрэглэгчийн тоо 55950 болж өмнөх оноос 2683 хэрэглэгчээр өссөн байна.



5.7. Хэрэглэгчдээс ирсэн санал хүсэлтийг шийдвэрлэсэн байдал:

2024 онд нийт 466 санал, гомдол хэрэглэгчдээс ирснээс хангамж, хэрэглээтэй холбоотой 324 буюу нийт саналын 70%-ийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 73 санал, хүсэлтээр өссөн байна.

Санал, гомдол (ангиллаар)

д/д	Хэрэглэгчдээс ирүүлсэн санал гомдол	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	Зөрүү
1	Цахилгаан хангамжийн чанар, хэрэглээтэй холбоотой	160	139	214	281	324	43
2	Төлбөр тооцоотой холбоотой	103	55	85	81	34	-47
3	Цахилгаан-хэмжих хэрэгсэл	4	3	6	16	28	12
4	Цахилгааны бусад	8	14	44	15	80	65
5	Ажилтны үйл ажиллагаатай холбоотой	0	5	0	0	0	0
6	Засгийн газрын чөлөөлөлттэй холбоотой	0	182	0	0	0	0
Нийт тоо		275	398	349	393	466	73

5.8. Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг таниулж сурталчлах, бодит мэдээллийг хүргэх, иргэдэд тулгамдсан асуудлыг сонсох, шийдвэрлэх, цахилгаан эрчим хүчний үнэ тариф, цахилгаан эрчим хүчийг хэрхэн хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх, оргил ачааллын талаар хэрхэн хэрэглээгээ зөв зохицуулах талаар аймаг сум, баг хороодын 4210 хэрэглэгчид уулзалт өдөрлөг зохион байгууллаа.

Мөн “Мэдээллийн цаг” уулзалт өдөрлөгийн хүрээнд төрийн болон хувийн хэвшлийн албан байгууллагуудын ажилтнуудад нөлөөллийн сургалтыг санаачлан зохион байгуулж хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчний хэмнэлт үр ашиг, зохистой хэрэглээ, эрчим хүчний үнэ тариф, шөнийн хөнгөлөлт, цахилгааны аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх арга замууд, төлбөрөө хялбар төлөх боломж, төлбөрөө төлөөд НӨАТ-ынн баримтаа хэрхэн авах, оргил ачааллын цагаар хэрэглээгээ хэрхэн зөв хэрэглэх зөвлөмжийг өгч, нийт 12 байгууллагын 171 ажилтан танхим болон цахимаар хамрагдсан.



Компанийн хэмжээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагааны талаар хэрэглэгч, олон нийтэд мэдээлэх, танилцуулах арга хэмжээг тогтмолжуулж, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллалаа.



Дорноговь Цахилгаан Түгээх Сүлжээ ...
Posted by Ln Chimeg
13 Dec 2024 · 🌐

DSB TV
13 Dec 2024 · 🌐
ЦАХИЛГААНЫ ҮНИЙН ТӨЛБӨР 2024 ОНЫ 11 САРЫН 15-НААС ААН-Д 30 ХУВЬ, АЙЛ ӨРХӨД 1 КВТ НЬ 35-130 ТӨГРӨГ... See more



2024 оны эрчим хүчний хэмнэлтийн жилийн төлөвлөгөөний дагуу БЗӨБЦТС ТӨХК-нийн харьяа Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Хэнтий, Багануур салбарын нийт 328 ажилтанд танхимаар, 31 ажилтанд цахимаар эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг хэрхэн гаргах талаар хэрэглэгч олон нийтэд таниулах, хэрэглээндээ хэмнэлт хийсэн айл өрхийг бусдад судлан таниулах, оргил ачааллыг бууруулах, сошиал орчинд эрчим хүчний хэмнэлтийн тухай мэдээ мэдээллийг шэйрлэн түгээх, ЭХЗХ-оос бэлдсэн шторк, контентыг сошиал орчинд түгээх сэдвээр сургалт зааварчилгааг өгч ажилласан.



Манай компанитай харилцдаг томоохон хэрэглэгч болон ЭХЗХ-оос үүрэг хүлээсэн хэрэглэгчидтэй уулзалт өдөрлөгийг хамтран зохион байгуулж тэдний санал бодлыг сонсож хамтран туршлага хуваалцах, эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлого, цаг үеийн байдал, хэрэглэгчдэд хуулиар олгогдсон эрх үүргийг таниулах, эрчим хүчний хэмнэлт зүй зохистой хэрэглээ, оргил ачааллыг цагаар эрчим хүчний чадлыг бууруулах талаар зорилтод бүлгүүдэд таниулах чиглэлээр мэдээ мэдээлэл хүргэлээ.

Өдөрлөгийг “Пума-империал” ХХК-ийн Империал танхимд 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж, уулзалтад 27 аж ахуйн нэгж байгууллагын нийт 50 хэрэглэгч, харьяа салбаруудын хангах үйл ажиллагаа хариуцсан менежер, борлуулалтын инженер, Эрчим хүч зохицуулах хорооны зөвлөх багш, ЭХХГ-ын мэргэжилтэн Б.Энхжаргал, Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн ГТТА-ны инженер Н.Буян-Өлзий, АТГ-ын ажилтан мөн МҮОНРТ, МОНЦАМЭ агентлагийн сурвалжлагчид оролцсон.



5.9. Дуудлагын төвийн үйл ажиллагаа

Тус компани нь цахилгаан эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангах үүргийн дагуу төв компани дээр 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “Дуудлагын төв”-ийн үйл ажиллагааг эхлүүлж, Улаанбаатар хотын Багануур дүүрэг, Хэнтий аймгийн Жаргалтхаан сум, Дэлгэрхаан сум, Цэнхэрмандал сум, Хэрлэнбаян-Улаан баг, Төв аймгийн Мөнгөнморьт сум буюу Багануур салбарын үйлчлэх хүрээний нийт 11713 хэрэглэгчид үйлчилгээ үзүүлж, дуудлагын утсанд 37522 хэрэглэгч хандсанаас холбогдсон хэрэглэгчийн тоо 30245 ба амжилттай дуудлагын хувь 80%, алдсан дуудлагын хувь 4%, хариулаагүй дуудлагын хувь 16% байна.

Дуудлагын төвд хүлээн авсан дуудлагын тоо хэмжээ


Үндсэн төрөл	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Нийт
Өргөдөл, гомдол	7	2	10	4	157	4	184
Мэдээлэл, лавлагаа,	0	107	1185	840	896	2228	5256
Техник үйлчилгээ	262	284	625	1071	662	845	3749
Хүсэлт	57	13	58	183	136	76	523
НИЙТ							



Нийт 184 өргөдөл, гомдол ирснээс 11 сард хамгийн өндөр буюу 157 буюу 85 хувь өргөдөл, гомдол хүлээн авсан нь цахилгаан хангамжийн хэрэглээ өсөж өвлийн их ачаалал нэмэгдэж Төвийн бүсийн эрчим хүчний систем чадлын дутагдалд орсноор ДҮТ ТӨХХК-аас “Багц 14”-ийн хөнгөлөлт хийсэн нь нөлөөлсөн.



Өргөдөл, гомдлын төрөл



Нийт 5256 хэрэглэгчдэд мэдээлэл өгснөөс 12-р сард хамгийн их буюу 2228 мэдээлэл хүргэсэн нь улирлын онцлог, цахилгаан хангамжийн нөхцөлтэй холбоотой ба 11, 12 сард ЦДҮС-ийн ЗӨБС-ын 220/110/35 кВ-ын Багануур д/ст-ын гэмтэл, ДҮТ ТӨХХК-аас багц 14 дагуу хийсэн хязгаарлалтууд нь нөлөөлсөн байна. Мөн сар бүрийн дундуур ЦЭХ-ний төлбөр лавласан дуудлага огцом ихэсдэг. Энэ нь мэдээлэл лавлагааны 3703 буюу 70 хувийг, таслалтай холбоотой мэдээлэл лавлагаа нь 1058 буюу 20 хувийг эзэлж байна.

Техник үйлчилгээтэй холбоотой дуудлага 7-12 сарын хугацаанд нийт 3749 ирснээс 9, 10-р сард хамгийн өндөр байна. Тэр дундаа хэрэглэгчдийн хүсэлтийн дагуу хийгдэх ажил, гэмтэл тасралттай холбоотой ажлууд их байгаа ба үүнд өвлийн бэлтгэл ажил хангах их засварын ажил болон иргэдийн төв рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдэж хувийн бэлтгэл ажлаа хангаж байгаа нь шууд нөлөөлсөн байна.

Дугаараа солих буюу хасах хүсэлтийн дуудлага 10 сард хамгийн их буюу 183 хүсэлт ирсэн ба үүнд мөн улирлын шинж чанараас хамаарч хэрэглэгчдийн шилжилт хөдөлгөөн шууд нөлөөлсөн харагдаж байна.

Багануур салбарын үйлчлэх хүрээнд дуудлагын программ нэвтэрснээс хойш ирсэн дуудлага мэдээллийн тоог хагас жилээр харьцуулж харуулбал:

Сараар	Хариулсан	Хариулаагүй	Автомат хариулагч сонссон	Алдсан	Нийт
1 сар	2381	271	203	0	2855
2 сар	1851	308	169	0	2328
3 сар	2907	758	244	6	3915
4 сар	2698	1067	197	7	3969
5 сар	3147	2010	272	10	5439
6 сар	3992	3077	0	9	7078
Эхний хагас жилд	16976	7491	1085	32	25584
7 сар	4899	1489	332	60	6780

8 сар	5383	899	296	82	6660
9 сар	4794	1417	230	128	6569
10 сар	4636	621	255	152	5664
11 сар	4078	675	91	627	5471
12 сар	4885	727	366	400	6378
Сүүлийн хагас жилд	28675	5828	1570	1449	37522

Сүүлийн хагас жилд дуудлагын утасны хандалтын тоо 46.7%-иар өссөн бөгөөд хариулах чадвар мөн 10%-иар сайжирсан байна. Энэ нь орон тоо бүтцийн хувьд нэмэгдэж, техник программ хангамж сайжирсантай холбоотой. Хариулсан дуудлагын эзлэх хувь 66%-аас 76% болж, хариулаагүй дуудлагын хувь 13%-иар буурсан. Энэ нь үйлчилгээний чанар дээшилснийг харуулж байна.

Сард дунджаар нэг оператор руу 790 дуудлага хандаж байгаагаас 550 дуудлага хүлээн авч, өдөрт дунджаар 57 дуудлага хандсанаас 42 дуудлага хүлээн авч ажилласан байна.

5.10. Тоолуур, хэмжүүрийн чиглэлээр

Тус компани нь Дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2”-ын хүрээнд ухаалаг тоолуур, өгөгдөл цуглуулагч, дагалдах программ хангамж AMI, MDM, EDIMIS системийг 2021 оны 06-р сараас эхлэн нэвтрүүлж 2024 оны 12 дугаар сард дуусгасан.

Уг төсөл хөтөлбөрийн хүрээнд нэг фазын 35,674 ш, гурван фазын 4,041 ш ухаалаг тоолуур, 432 ш өгөгдөл цуглуулагчийг төсөл хэрэгжиж буй 7 цэг болох Багануур дүүрэг, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймгийн төвүүд, Замын-Үүд, Бор-Өндөр сумдад суурилуулж HES системд холбосон.

Тус компанийн үйлчлэх хүрээний цахилгаан эрчим хүч хэрэглэгчдэд Монгол Улсад мөрдөгдөж буй зохих стандартын шаардлага хангасан ухаалаг тоолуур, дата концентраторыг албан ёсны эрхтэй гэрээт борлуулагч хуулийн этгээдээс хүлээн авч, зах зээлд борлуулж буй үнээр аливаа нэмэлт төлбөр, зардал нэмж тооцохгүйгээр хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан тоолуур, хэмжих хэрэгслээр хангах, алслагдсан хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй түргэн шуурхай байдлаар үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулж, нийгмийн хариуцлагын хүрээнд ухаалаг тоолуур зуучлалын гэрээний төслийг баталгаажуулж “ДСЦТС” ХК-р баталгаажуулахаар илгээгээд байна.

Тус компанийн тоолуур хэрэглэгчдийн тоог хэрэглээний төрлөөр нь ангилж хүснэгтэд харуулав.

Д/д	Хэрэглэгчийн ангилал	Ухаалаг тоолуур	Бусад тоолуур	Нийт тоолуур	Ухаалаг тоолуурын эзлэх хэмжээ (%-р)
1	2	3	4	5	6
1	Гэр хороолол	18,327	12,928	31,255	58.64 %
2	Орон сууц	16,850	1,418	18,268	92.24 %

3	ААНБ	3,348	3,079	6,427	52.09 %
4	Нийт	38,525	17,425	55,950	68.86 %

Нийт гэмтэлтэй 1 фазын ухаалаг тоолуур 79 ширхэг, 5 А-ын ухаалаг тоолуур 1 ширхэг, 100 А-ын ухаалаг тоолуур 3 ширхэг, 100 В-ын ухаалаг тоолуур 2 ширхэг, дата концентратор 9 ширхэг, 3 фазын тоолуурын ВРLС модуль 9 ширхэг, 1 фазын тоолуурын ВРLС модуль 3 ширхэгийг тус тус шинээр солиулж харьяа салбаруудад хүргүүлсэн.

2024 онд Тоолуур хэмжүүрийн албаны лабораторид 1 фазын тоолуурын модуль 10 ширхэг, 3 фазын тоолуурын модуль 10 ширхэг, 1 болон 3 фазын 60 ширхэг тоолуурын гадна батареийг сольж, засварлан, харьяа салбарууд, орон нутгууд дахь Стандарт хэмжил зүйн хэлтсүүдтэй хамтарч 1 болон 3 фазын нийт 1637 ширхэг тоолуурын ээлжит баталгаажуулалтыг зохион байгуулж харьяа салбаруудын дансанд нийт 14,283,500 төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Мөн 24 гүйдлийн, хүчдэл трансформаторт хэмжилт хийсэн.



Алдагдал ихтэй сумдын алдагдлыг бууруулах зорилгоор 35/10 кВ-ын Галшар дэд станцын 10 кВ-ын Дэлгэрэх гаргалгааны 50/5 А-тай гүйдлийн трансформаторыг 200/5 А-тай гүйдлийн трансформатораар сольж буусан 50/5 А-тай гүйдлийн трансформаторыг 10 кВ-ын сумын төв гаргалгаанд сольж тавьсан. 10 кВ-ын шинийн баланс 1.62 %-тай бариулсан.

Дорноговь ЦТССалбарын ээлжит баталгаажуулалтаар Сайншанд сумын төвөөс буусан албаны импульсийн 130 ширхэг тоолуурыг Өргөн, Зүүнбаян сумдын нарийвчлалын анги өндөр механик тоолуурын оронд сольж суурилуулсан. Цаашид ээлжит тоолуур баталгаажуулалтаар механик тоолуурыг хэрэглээнээс хасах, механик тоолуурт баталгаажуулалт хийхгүй байхаар чиглэл өгсөн.

Говьсүмбэр ЦТССалбарын Сүмбэр сумын төвөөс буусан албаны DDS-3 маркийн импульсийн 500 ширхэг тоолуурыг Говь-Угтаал, Даланжаргалан, Айраг сумдын баталгаажуулалтад хамрагдах механик тоолуурын оронд баталгаажуулалтад хамруулж хэрэглэгчдэд албан ёсоор мэдэгдэж суурилуулсан.

Говьсүмбэр ЦТССалбарын Даланжаргалан, Дорноговь ЦТССалбарын Өргөн сумдын 200 гаруй ширхэг механик тоолуурыг DDS-3 маркийн импульсын тоолуураар сольж суурилуулснаар 2024 оны 11-р сарын түгээлтийн алдагдал өмнөх оны мөн үе 11-р сараас 1.75-2.07 %-иар буурсан байна.

ЗУРГАА.ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

6.1. Компанийн 2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор батлагдсан дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт, Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаал зэргийг үндэслэн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан.

2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 100 нэр төрлийн 9,162.6 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтын 29 нэр төрлийн 6,828.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ, харьцуулалтын аргаар 36 нэр төрлийн 1,824.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ, шууд худалдан авалтаар 35 нэр төрлийн 509.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгөөнд тусгагдсан.

Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан 29 тендерээс 29 тендерийг амжилттай зохион байгуулж гэрээ хийн ажилласан. Харьцуулалтын аргаар зохион байгуулсан 36 тендерээс нэг тендер төлөвлөгөөнөөс хасагдаж 35 тендерийг амжилттай зохион байгуулсан. 35 шууд худалдан авалтаас 20 шууд худалдан авалтын эрхийг салбарт шилжүүлэн худалдан авалтыг хийж нэг ажил төлөвлөгөөнөөс хасагдсанаар 34 шууд худалдан авалтыг амжилттай зохион байгуулаад байна.

Нийт 100 нэр төрлийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөж ажилласнаас 2 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ хасагдаж 64 тендер, 34 шууд худалдан авалтыг амжилттай зохион байгуулж төлөвлөгөөний гүйцэтгэл 100 хувьтай байна.

ШХА №24/24 дугаартай НҮВА-402 загварын гүйдэл, хүчдэлийн трансформатор шалгах зөөврийн төхөөрөмж засварлах шууд худалдан авалт тухайн төхөөрөмж БНХАУ-д дахин үйлдвэрлэхээ больсон тул сэргээн засварлах боломжгүй болж төлөвлөгөөнөөс хасагдсан. ХА №24/10 дугаартай Япон автомашины засварын ажлын тендер тухайн автомашин актлагдсан тул мөн төлөвлөгөөнөөс хасагдсан.

6.2. Худалдан авалтын хэмнэлт

Компанийн 2024 оны худалдан авах ажиллагаанд хэмнэлт хийгдсэн байдал:

д/д	Тендер шалгаруулалтын журам	Батлагдсан төсөв	Хэмнэлт
1	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	6,828,615,900.00	308,196,715.00
2	Харьцуулалтын тендер	1,824,149,520.00	178,731,322.00
3	Шууд худалдан авалт	509,795,400.00	79,747,745.00
НИЙТ		9,162,560,862.00	566,675,824.00



6.3. Сангийн яаманд гаргасан гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдал

2024 оны худалдан авах ажиллагааны явцад Сангийн яаманд тендер шалгаруулалтын үр дүнтэй холбоотой 3 гомдол гарсныг хуулийн дагуу шийдвэрлэж ажилласан.

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил үйлчилгээний нэр төрөл	Гаргасан гомдол	Сангийн яамны шийдвэр	Тайлбар
1	Ажлын бээлий, бусад хэрэгсэл Төсөвт өртөг /сая.төг/: 41,1 Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам.: НТШ №24/20 Багц №3 Шалгарсан оролцогч: Их газрын чулуу ХХК Гэрээний дүн /сая.төг/: 34,892,040	Баян хайрхан баян булаг ХХК нь Сангийн яаманд гомдол гаргасан.	Сангийн яам хянан үзэж 2024 оны 05 сарын 30 өдрийн шийдвэрээр гомдол үндэслэлтэй байна гэж үзсэн тул дахин хянан үзэх шийдвэр ирсэн.	Уг оролцогчийн ирүүлсэн тендерийг Сангийн яамны шийдвэрийн дагуу хянан үзээд ирүүлсэн тендерийг шаардлагад нийцэхгүй гэж шийдвэрлэж уг тендер дахин зарлагдсан.
2	Ажлын бээлий, бусад хэрэгсэл Төсөвт өртөг /сая.төг/: 41,1 Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам.: НТШ №24/20 Багц №3 Шалгарсан оролцогч: Замилаа богд ХХК Гэрээний дүн /сая.төг/: 21,965,350	Баян өндөр ХХК нь Сангийн яаманд гомдол гаргасан.	Сангийн яам хянан үзэж 2024 оны 10 сарын 10 өдрийн шийдвэрээр гомдол үндэслэлтэй байна гэж үзсэн тул дахин хянан үзэх шийдвэр ирсэн.	Уг оролцогчийн ирүүлсэн тендерийг Сангийн яамны шийдвэрийн дагуу хянан үзээд ирүүлсэн тендерийг шаардлагад нийцэхгүй гэж шийдвэрлэж уг тендер дахин зарлагдсан.
3	Ажлын бээлий, бусад хэрэгсэл Төсөвт өртөг /сая.төг/: 41,1 Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам.: НТШ №24/20 Багц №3 Шалгарсан оролцогч: Их газрын чулуу ХХК Гэрээний дүн /сая.төг/: 33,868,480	Харцал харгиа ХХК нь Сангийн яаманд гомдол гаргасан.	Сангийн яам хянан үзэж 2024 оны 07 сарын 26 өдрийн шийдвэрээр гомдол үндэслэлтэй байна гэж үзсэн тул дахин хянан үзэх шийдвэр ирсэн.	Уг оролцогчийн ирүүлсэн тендерийг Сангийн яамны шийдвэрийн дагуу хянан үзээд ирүүлсэн тендерийг шаардлагад нийцэхгүй гэж шийдвэрлэж уг тендер дахин зарлагдсан.

6.4. Дотоодын үйлдвэрээс худалдан авсан бараа, бүтээгдэхүүн

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтыг үндэслэн, 2024 онд дараах бараа бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрээс худалдан авсан.

2024 ОНД ДОТООДЫН ҮЙЛДВЭРЭЭС БАРАА ХУДАЛДАН АВАЛТ ХИЙСЭН БАЙДАЛ

№	Төсөл арга хэмжээний нэр, /багцын дугаар/	Бараа бүтээгдэхүүний ерөнхий ангилал	Тухайн жил дотоодын үйлдвэрээс худалдан авсан бараа, бүтээгдэхүүний нэр төрөл	Гүйцэтгэчийн нэр, регистр	Гэрээний дүн
1	Төмөр бетон тулгуур	12.13	Инженерийн байгууламжийн төмөр бетон бүтээц, хийц хэрэгсэл, төмөр бетон тулгуур, шон	Эрчим тулгуур ХХК	496,820,500.00
2	Төмөр бетон хийц	12.13	Инженерийн байгууламжийн төмөр бетон бүтээц, хийц хэрэгсэл, төмөр бетон тулгуур, шон	Хулконсалтинг ХХК	83,584,000.00
3	Хөдөлмөр хамгаалалын хувцас	4.4	Бүх төрлийн хөдөлмөр хамгааллын хувцас, малгай, бээлий;	МТОТ ХХК	139,277,787.00
4	Хөдөлмөр хамгаалалын гутал	4.4	Бүх төрлийн хөдөлмөр хамгааллын хувцас, малгай, бээлий;	Баянцагаан нуур ХХК	70,073,080.00
5	Цахилгаан дамжуулах АС утас	12.15	Өнгөт төмөрлөг бүтээгдэхүүн/катодын зэс, зэсийн хайлш, зэс утас, зэс голтой уян кабель, бүрээсгүй хөнгөн цагаан (ган голтой) АС утас, хөнгөн цагаан голтой бүрээстэй СИП кабель, хүчний болон хоёрдогч хэлхээний кабель, холбогч эд анги;	Ар хөв энерги ХХК	110,698,913.00
6	Цахилгаан дамжуулах СИП утас	12.15	Өнгөт төмөрлөг бүтээгдэхүүн/катодын зэс, зэсийн хайлш, зэс утас, зэс голтой уян кабель, бүрээсгүй хөнгөн цагаан (ган голтой) АС утас, хөнгөн цагаан голтой бүрээстэй СИП кабель, хүчний болон хоёрдогч хэлхээний кабель, холбогч эд анги;	Ар хөв энерги ХХК	237,150,870.00
7	Ажлын бээлий, бусад хэрэгсэл	4.4	Бүх төрлийн хөдөлмөр хамгааллын хувцас, малгай, бээлий;	Замилаа Богд ХХК	21,192,050.00
8	Ажлын байрны цэвэрлэгээний материал	11.13	Цэвэрлэгээ, үйлчилгээний зориулалттай гадаргуугийн идэвхт бүтээгдэхүүн, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл;	Эн Жи Галатик ХХК	34,989,570.00
9	Бүх төрлийн журнал, гэрээний дэвтэр, бланк маягууд	1.5	Албан бланк, дугтуй, төсвийн байгууллагын бүх төрлийн хэвлэмэл материал;	Соёмбо принтинг ХХК	21,390,200.00
Дотоодын үйлдвэрээс худалдан авсан барааны нийт дүн:					1,215,176,970.00



ДОЛОО. 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ

2025 онд дараах томоохон зорилтуудыг дэвшүүлж, биелэлтийг ханган ажиллахаар төлөвлөсөн. Үүнд:

1. Үйлдвэрлэлийн осол гаргалгүй ажиллах;

2. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

- Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлагдсан компанийн бүтэц зохион байгуулалтад тулгуурлан, ажил мэргэжлийн жагсаалтыг оновчтой болгож, хүн нэг бүрийн хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх;
- Хамт олны дунд эерэг уур амьсгалыг бүрдүүлж, хүний нөөцийн тогтворжилтыг дээшлүүлэх;
- Компанийн дотоод дүрэм, журмуудыг цаг үеийн байдал болон доголдсон үзүүлэлттэй уялдуулж сайжруулах;
- Хэрэглэгчийн эрх ашигт нийцсэн бодлого хэрэгжүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулан, олон нийтэд компанийн нэр хүндийг өсгөх.

3. Цахилгаанаар зохицуулалттай хангах, түгээх ажлын хүрээнд:

- Цахилгаан түгээлтийн алдагдлыг 0.5 нэгжээр бууруулж, компанийн орлогыг нэмэгдүүлэх;
- Цахилгаан тасалдлын индексийг 20 хувиар бууруулах;
- “Эрчим хүчний төсөл-2”-т хамрагдаагүй компанийн эзэмшлийн 50 сум, суурин газрын 21.0 мянга орчим тоолуурыг ухаалаг тоолуураар шинэчлэх ажлыг ЭХЗХ-ны тарифын зохицуулалтаар шийдвэрлүүлэх;
- Компани ухаалаг тоолуурын систем болон хангамжийн хувьд нэг үйлдвэрлэгчээс хараат байдлаас гарах, чөлөөт өрсөлдөөнийг үүсгэх.